



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/45/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: tsaranchimeg@audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/148
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй, холбогдох заалтыг зөрчин компьютер техник хэрэгслийн үнэ, цахилгааны монтаж солих үндсэн хөрөнгийн их засварын зардалд 40,094.4 мянган төгрөгийн зардал гаргасан, хорголжин тэжээл 9,000.0 мянган төгрөгөөр бэлтгэсэн ч малчдад борлуулаагүй, 74,757.8 мянган төгрөгийн худалдан авалтыг е-баримтаар баталгаажуулаагүй, төсөвт төвлөрүүлэх 4,994.4 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төвлөрүүлээгүй, нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлөөгүйгээс 1,403.5 мянган төгрөгийн алдангийг төсвөөс төлж төсвийг үргүй зарцуулсан зэрэг нийт 130,250.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс 48,011.4 мянган төгрөгөөс хэтэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

D 2022/2022 ОН УЛСЫН БИШГ 19030/72

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,236,724.05	69,706,452.05
33	АВЛАГА	24,630,000.00	2,000,000.00
335	Бусад авлага	24,630,000.00	2,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	22,630,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,000,000.00	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,606,724.05	67,706,452.05
354	Хангамжийн материал	41,879,524.05	42,509,982.05
35410	Бичиг хэргийн материал	1,448,302.00	1,447,983.00
35420	Аж ахуйн материал	547,800.00	1,029,400.00
35440	Түлш, шатах тослох материал	2,704,005.05	3,665,090.05
35450	Барилгын засварын материал	791,800.00	2,161,900.00
35470	Бусад хангамжийн материал	36,387,617.00	34,205,609.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,261,466,475.25	1,208,012,403.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,261,466,475.25	1,208,012,403.79
392	Биет хөрөнгө	1,070,125,919.57	1,018,445,348.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,012,412,775.49	1,032,318,182.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(186,891,355.36)	(226,436,155.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	238,589,555.00	183,599,555.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(184,593,589.14)	(153,105,360.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	136,833,820.92	100,148,235.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(111,447,965.59)	(68,623,665.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,268,091.10	76,216,117.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(48,680,480.69)	(52,613,033.60)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,063,506,328.00	1,063,506,328.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,050,340,340.68)	(1,052,442,944.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	230,832,829.00	221,210,529.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(109,067,148.48)	(106,375,839.42)
39217	Ном	703,400.00	1,043,400.00
393	Биет бус хөрөнгө	191,340,555.68	189,567,055.68
39301	Програм хангамж	1,645,000.00	1,645,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(781,944.44)	(989,444.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	198,170,000.00	199,170,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(7,692,499.88)	(10,258,499.84)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,339,703,199.30	1,277,718,855.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,339,703,199.30	1,277,718,855.84
51	Засгийн газрын хувь оролцоо	1,339,703,199.30	1,277,718,855.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын	1,009,750,503.06	1,009,750,503.06
51101	Өмч: - төрийн	1,009,750,503.06	1,009,750,503.06
512	Хуримтлагдсан үр дүн	103,045,287.41	41,060,943.95
51210	Өмнөх үеийн үр дүн	103,045,287.41	103,045,287.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	(61,984,343.46)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,907,408.83	226,907,408.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,339,703,199.30	1,277,718,855.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	690,460,230.00	665,972,659.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,148,983.00	23,808,190.00
120	Нийтлэг татварын бус орлого	99,148,983.00	23,808,190.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	591,311,247.00	640,164,469.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	2,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,841,047.00	46,630,769.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	-	7,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	12,416,347.00	26,694,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	16,424,700.00	12,736,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	593,533,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	-	593,533,700.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	562,470,200.00	-
1330	Төсвийн захирагчдаас	562,470,200.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	696,486,967.39	725,784,135.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	677,786,967.39	705,804,135.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	611,282,014.41	614,719,542.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,546,944.53	263,441,674.00
210101	Үндсэн цалин	180,475,538.45	181,644,345.00
210102	Нэмэгдэл	39,980,496.28	37,461,816.40
210105	Гэрээт ажлын хөлс	27,090,909.80	44,335,512.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,374,170.48	34,215,962.12
210201	Тэтгэврийн даатгал	24,248,010.45	24,210,441.70
210202	Тэтгэмжийн даатгал	2,511,157.63	2,599,510.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,094,713.54	2,074,811.19
210204	Ажилгүйдлийн даатгал	501,807.75	483,314.16
210205	Эрүүл мэндийн даатгал	5,018,481.11	4,847,884.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,931,092.95	49,407,918.00
210301	Гэрэл, цахилгаан	10,728,553.00	12,029,575.00
210302	Түлш, халаалт	32,202,539.95	37,378,343.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,936,290.75	46,177,736.25
210401	Бичиг хэрэг	7,329,642.75	2,919,619.00
210402	Тээвэр, шатахуун	11,881,492.00	8,969,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,777,176.00	1,302,370.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	30,333,769.25
210408	Бараа материал акталсны зардал	947,980.00	2,652,408.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,865,690.00	6,690,100.00
210604	Урсгал засвар	8,865,690.00	6,690,100.00

**Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	3,016,000.00	1,608,000.00
210702	Дотоод албан томилолт	3,016,000.00	1,608,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,783,940.01	2,929,398.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	63,649,505.01	1,803,338.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	292,575.00	309,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	378,860.00	353,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	187,827,885.69	210,248,754.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,877,763.00	104,843,142.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	130,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,950,122.69	105,275,611.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,504,952.98	91,084,592.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,007,400.00	31,276,056.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,097,400.00	22,807,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	910,000.00	8,468,656.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,648,355.98	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,648,355.98	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	1,849,197.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,849,197.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	59,808,536.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,700,000.00	19,980,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,700,000.00	19,980,000.00
221001	Их засвар	18,700,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	-	19,980,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(6,026,737.39)	(59,811,476.85)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	155,456.16	2,172,866.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	155,456.16	2,172,866.61
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(155,456.16)	(2,172,866.61)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,182,193.55)	(61,984,343.46)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	103,045,287.41	1,339,703,199.30
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	103,045,287.41	1,339,703,199.30
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	103,045,287.41	1,339,703,199.30
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-61,984,343.46	-61,984,343.46
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	41,060,943.95	1,277,718,855.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	591,311,247.00	642,164,469.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	591,311,247.00	642,164,469.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,841,047.00	48,630,769.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	-	7,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	12,416,347.00	26,694,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	16,424,700.00	12,736,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	562,470,200.00	593,533,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	562,470,200.00	593,533,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	571,112,147.00	582,090,062.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	571,112,147.00	582,090,062.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,607,194.02	489,912,969.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,546,944.53	263,441,674.00
210101	Үндсэн цалин	180,475,538.45	181,644,345.00
210102	Нэмэгдэл	39,980,496.28	37,461,816.40
210105	Гэрээт ажлын хөлс	27,090,909.80	44,335,512.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,374,170.49	34,215,962.12
210201	Тэтгэврийн даатгал	24,248,010.46	24,210,441.70
210202	Тэтгэмжийн даатгал	2,511,157.63	2,599,510.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,094,713.54	2,074,811.19
210204	Ажилгүйдлийн даатгал	501,807.75	483,314.16
210205	Эрүүл мэндийн даатгал	5,018,481.11	4,847,884.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,461,800.00	50,437,338.00
210301	Гэрэл, цахилгаан	8,370,759.00	12,329,575.00
210302	Түлш, халаалт	32,091,041.00	38,107,763.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,407,018.00	47,809,828.00
210401	Бичиг хэрэг	2,839,500.00	2,517,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,688,912.00	9,286,933.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,878,606.00	1,199,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	34,805,945.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,500,000.00
2107	Томилголт, зочны зардал	3,016,000.00	1,608,000.00
210702	Дотоод албан томилолт	3,016,000.00	1,608,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,047,970.00	2,193,558.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	75,913,535.00	1,067,498.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	292,575.00	309,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	378,860.00	353,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,753,291.00	88,706,609.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,753,291.00	88,576,609.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	130,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,504,952.98	92,177,092.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,007,400.00	32,368,556.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	8,368,656.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,097,400.00	22,807,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	910,000.00	1,192,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,648,355.98	59,808,536.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,648,355.98	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	1,849,197.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,849,197.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,199,100.00	60,074,407.00

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,199,100.00	60,074,407.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,199,100.00	60,074,407.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,199,100.00	60,074,407.00
221001	Их засвар	18,754,500.00	-
222001	Тоног төхөөрөмж	-	19,980,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,444,600.00	40,094,407.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(20,199,100.00)	(60,074,407.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,007,000.00	540,587,497.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	740,007,000.00	520,607,497.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,348,300.00	488,238,941.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,976,300.00	263,441,674.00
210101	Үндсэн цалин	189,848,900.00	181,644,345.00
210102	Нэмэгдэл	48,245,700.00	37,461,816.40
210105	Гэрээт ажлын хөлс	47,881,700.00	44,335,512.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,606,700.00	34,215,962.12
210201	Тэтгэврийн даатгал	27,167,800.00	24,210,441.70
210202	Тэтгэмжийн даатгал	2,859,700.00	2,599,510.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,287,800.00	2,074,811.19
210204	Ажилгүйдлийн даатгал	571,900.00	483,314.16
210205	Эрүүл мэндийн даатгал	5,719,500.00	4,847,884.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,880,400.00	50,437,338.00
210301	Гэрэл, цахилгаан	9,187,800.00	12,329,575.00
210302	Түлш, халаалт	41,492,600.00	38,107,763.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	49,209,200.00	47,809,828.00
210401	Бичиг хэрэг	2,397,600.00	2,517,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,611,600.00	9,286,933.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,199,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,000,000.00	34,805,945.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,977,500.00	1,608,000.00
210702	Дотоод албан томилолт	5,977,500.00	1,608,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,166,500.00	1,126,060.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	309,700.00	309,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,800.00	353,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	271,031,700.00	88,100,079.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	271,031,700.00	88,100,079.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,658,700.00	32,368,556.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,658,700.00	32,368,556.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,651,300.00	8,368,656.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,807,400.00	22,807,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,192,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,000,000.00	19,980,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	38,000,000.00	19,980,000.00
222001	Тоног төхөөрөмж	20,000,000.00	19,980,000.00
223001	Бусад хөрөнгө	18,000,000.00	-
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	778,007,000.00	593,533,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	778,007,000.00	593,533,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	778,007,000.00	593,533,700.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	41,768,435.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,991,852.00	41,768,435.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,991,852.00	41,768,435.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,416,085.00	1,067,498.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,416,085.00	1,067,498.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,575,767.00	40,700,937.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,575,767.00	40,570,937.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	130,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,841,049.00	46,630,769.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,841,049.00	46,630,769.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	7,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,416,349.00	26,694,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,424,700.00	12,736,200.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох е баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 03/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар нь сумын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, захиргааны удирдлага, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, байгууллагын хүний нөөцийг сайжруулах, хувь хүний чадавх, харилцаа хандлагыг өөрчлөхөд анхаарч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд дэмжлэгийг үзүүлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/01 тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын багийг, дотоод хяналт зохион байгуулах журмын хамтаар баталсан байна. Тайлант онд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас өвсний тооцоог шалгасан байна. 12 дугаар сард Аймгийн Засаг даргын үзлэг хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 690,460.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,356.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 7,767.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 9,974.6 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 382.3 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 7,480,9 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 593,533.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 46630.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 22,808.2 мянган төгрөг, өмнөх оны шилжих үлдэгдлээс 2,000.0 мянган төгрөг, нийт 664,972.7 мянган төгрөг өмнөх оноос 25,487.5 мянган төгрөгөөр буюу 3,69 хувиар буурсан байна.

Зардал:

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 725,784.1 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 582,090.1 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 540,587.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140255001 тоот дансанд 2021 онд 593,533.7 мянган төгрөгийн орлого, 593,533.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140255408 тоот дансанд 48,630.8 мянган төгрөгийн орлого төвлөрч, 48,630.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	24,630.00	2,000.00	22,630.00
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	53,606.72	67,706.45	(14,099.73)
Үндсэн хөрөнгө	1,261,466.48	1,208,012.40	53,454.07
Нийт хөрөнгө	1,339,703.20	1,277,718.86	61,984.34
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	1,339,703.20	1,277,718.86	61,984.34
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,339,703.20	1,277,718.86	61,984.34

Авлагын дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг болж 22,630.0 мянган төгрөгөөр буурсан нь түймрийн харуулын цамхаг 9,900.0 мянган төгрөг, өвс тэжээл 9,000.0 мянган төгрөг, машины дугуй 730.0 мянган төгрөг, Зурамтайн адгийн булгийн эх хаших 3,000.0 мянган төгрөгийн ажлыг хүлээн авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67,706.5 мянган төгрөг болж 14,099.7 мянган төгрөгөөр өссөн нь хорголжин тэжээл 9,000.0 мянган төгрөгөөр, хүнсний материал 4,469.3 мянган төгрөг, барилгын засварын материал 1,370.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,208,012.4 мянган төгрөг болж 53,454.1 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 62 тоот тогтоолоор 54,990.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг актлахаар шийдвэрлэж дуудлага худалдаагаар зарагдсан, мөн Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 57 тоот тогтоолоор 18 нэр төрлийн тоног төхөөрөмж 56,534.6 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,051.9 мянган төгрөг, бусад хөрөнгө 22,522.3 мянган төгрөг, нийт 136,098.9 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,277,718.9 мянган төгрөг болж 61,984.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 617,855.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 617,855.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 22,042.3 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 595,812.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь бусад хангамж бараа, материалын зардал 10,113.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8,859.3 мянган төгрөг, албан томилолтын зардал 3,397.5 мянган төгрөг, тогтмол зардал 1,673.8 мянган төгрөгийн зардал тус тус бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 595,812.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 595,812.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулан 595,812.8 мянган төгрөгөөр баталсан дүнгээс аймгийн СТСХ-ийн зарцуулах эрхийг Сангийн Яамнаас нээлгэсэн 778,007.0 мянган төгрөгөөс 182,194.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байсанд төлөвлөгөөнд нийцүүлэн залруулга хийсэн болно.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 593,533.7 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 540,587.5 мянган төгрөгийг зарцуулж, 52,946.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 540,587.5 мянган төгрөг буюу 90.7 хувь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар нь нийт 48,630.8 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 40,701.0 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,067.5 мянган төгрөг, нийт 41,768.4 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны батлагдсан зардлаас Ковидын үед сумын нөөцөд халдвар хамгааллын хувцас ариутгалын бодисын үнэ, ажилчдад халдвар хамгааллын

материалын үнэ нийт 3,022.0 мянган төгрөг, ЭМТ-д хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат 1,500.0 мянган төгрөг, нийт 4,522.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн аймгийн Засаг даргын А/72 дугаар захирамжаар 1,500.0 мянган төгрөг ирүүлснийг эм, эмнэлгийн хэрэгсэлд, мөн аймгийн Засаг даргын А/518 дугаар захирамжаар 5,000.0 мянган төгрөг, иргэдийн хандиваар 7,200.0 мянган төгрөг ирүүлснийг Ковид-19 бэлтгэл бэлэн байдлын зардал болон бусад зардалд 4,808.3 мянган төгрөг, шүлхий гарсантай холбогдуулан шатахуун, постын хяналтын зардалд 4,418.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Батсүмбэр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Хөрөнгө шийдвэрлэх тухай” 57 дугаар тогтоолын дагуу тайлант онд үндсэн хөрөнгийн данснаас 136,098.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассан.

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 53,994.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, сумын ИТХ-ын тогтоолоор 136,098.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн байршуулсан эсэхийг шалгасан. Мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 48,630.8 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг бүрэн оруулах, албан журмын даатгалын хураамжийг даатгуулагчаар төлүүлэх 2 зөвлөмжийг 100.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 07/158 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны тооцоо бодолтыг шалгах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 131,495.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,245.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 123,852.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6,397.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 1,245.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Анусервис ХХК, Дулаан түгээх хөгжил ХХК -тай хийсэн ковшоор нүүрс ачих түрээсийн гэрээгээр нийт 12,486.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогын Аудитын код ТӨА-2022/45/-НА-СТА-ТШЗ

дансанд төвлөрүүлснээс түрээсийн орлогын 40 хувь болох 4,994.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 23.3-д "Татварын бус орлого нь ... орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, ... хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 тоот тогтоолын 2-д "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгээс 40 хувиар тогтоосугай" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.2-д "төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсан орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй" бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

ЗДТГ нь 2016-2017 онуудад ажилчдад олгосон урамшуулал, морин эргүүлийн хөлс, гэрээт ажлын хөлс, багшийн хөлс, нохой устгалын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүйгээс 1,403.5 мянган төгрөгийн алдангийг төсвөөс төлж төсвийг үргүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 74,757.8 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй ба анхан шатны баримтад хүлээн авсан, өгсөн хүний гарын үсэг, шалгасан нягтлан бодогчийн гарын үсэг бүрэн зурагдаагүй, тамга тэмдэг дарж албажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 "Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ..." гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

ЗДТГ нь 2021 оны 02 дугаар сарын 23-нд хорголжин тэжээл /50 кг/ нэг бүрийн үнэ 32,259.00 төгрөгөөр 279 ширхэг нийт 9,000.0 мянган төгрөгийн тэжээлийг орлого авч, борлуулаагүй үр ашиггүй хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Ихрийн бууц ХХК, Сорос компьютер ХХК-уудаас компьютер техник хэрэгслийн үнэ, цахилгааны монтаж солих үндсэн хөрөнгийн их засварын зардалд 40,094.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар	6	131,495.4	1	1,245.2	2	6,397.9	3	123,852.2	0	0